

# МОНГОЛЬН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Хүн ам 3,087,432... УСХ-ны очигдрийн мэдээгээр

2016.06.06. Даваа. №114 (4484)

ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ

Худалдах унэ 500 төг

**ҮЗЭЛ БОДОЛ**ЖОН КЕРРИ АРДЧИЛЛЫГ  
ОНЦЛОХЫН УЧИР...

III нүүрт

**ОНЦЛОХ ХУУЛАС**ШАТАХ ЁСТОЙ БОЛ ШАТЯА ГЭЖ  
УРИАЛАХ НЬ ЗӨВ YY

V нүүрт

**УЛСТӨРЧИЙН ХӨРӨГ**

Дугаарын 60 мөр

Сонгуулийн  
хууль дэндүү  
чангаджээ

Ч.НОРЖИН

УИХ-ын болоод Орон нутгийн сонгууль хэлхэд 24 хоног үлдэжээ. Өмнө нь бүх шатны сонгуулиуд тус тусдаа УИХ-ын сонгуулийн тухай, Ерөнхийлögчийн сонгуулийн тухай хууль гэж мэт хуултат, түүгээрээ зохицуулагдаг байлаа. Харин энэ удаад үүнийг оорчилж бүх шатны сонгуулийг нэг хуулиар зохицуулж байхаар болов. Нөгөөтэйгүүр хуулийн шинэ орчин нь дэндүү хатуу болсон талаар нэр дэвшигчид дээр дооргүй л шүүмжилж байна. Аягүй л бол сонгууль болоод онгорсний дараа нэр дэвшигчийн ихэнх нь хууль зорчсон гэдэг асуудлаар шүүхийн хаалга татаж балрах вий. Хуульд заасанчлан УИХ-ын Сонгуулийн сургалчилгаа энэ сарын 11-ээс эхлэх ёстой. Учир иймээс нэр дэвшигчид сургалчилгаа эхээх албан ёсны одрийг хүлээн дэмий хөтөвэгээж байгаа байх.

Үргэлжлэл нь III нүүрт

## ҮЗЭЛ БОДОЛ

# ХАН-УУЛ, БАГАХАНГАЙД НЭР ДЭВШИГЧИЙН ХЭН НЬ ХЭН БЭ

**БӨНӨРТОГОТОХ**

З.Энхболд даргын удирдсан парламентийн халааг авах 76 эрхэм хэн байх вэ гэдэг их сунгаа эхэлсэн энэ үед хэвлэл мэдээлэл бүр өөрийн онцгоор үзүүлэлт дүгнэлт огч байна. “Монголын мэдээ” сонин хотын тойргуудыг тоймлон цуврал нийтлэлээ хүргэээр шийдэж, энэ удаагийн дугаартгаа нийслэлийн Хан-Уул, Багахангайг дүүргийг онцолж, тус тойргийн дөрвөн мандатын төлөө орсож буй нэр дэвшигч нэг бурийг унишигчиддаа танилцуулахыг зорилоо. Өмнөх дугаартгаа бид Баянзүрх дүүргийг онцолж, нэр дэвшигчийн талаар дэлгэрэнгүй танилцуулга

хүргэсэн билээ. Сонгогчид илүү их мэдээлэл авч, хэн нь хэн бэ гэдгийг таньдаг, мэддэг байгаасай гэсэн үднээс бүх намууд болон бие даагчдыг ч нэр ус, албан тушаалтай нь тоймлөй.

**МАНАН НЭГ НЭГЭНДЭЭ  
БЭЛЭГ БАРИВ УУ**

Хан-Уул, Багахангайд өмнөх сонгуулиар Багануур дүүргээ нэгдэж нэг тойрог болж байсан. Тэгвэл оноо жилийн сонгуулиар Багахангайг нэгтгэж дөрвөн мандаттай байхаар болжээ.

Үргэлжлэл нь III нүүрт

**Улаанбаатар: ӨНӨӨДӨР**

Өдөр +22

Шöнө +7



## СЭТГЭЛ БАЙХАД ШИЙДЭЛ ОЛДДОГ

Дэлгэрэнгүй ярилцлагыг IV нүүрнээс



## ХОНКОНГ РУУ НИСЛЭГ ҮЙЛДЭЭД

### 5 ЖИЛ БОЛЖЭЭ

Үндэсний Агаарын Тээвэрлэгч МИАТ ТӨХХ өнөөдрөөс яг 5 жилийн өмнө Хонг Конг хот руу тогтмол шууд нислэг анх үйлдэж эхэлсэн билээ. МИАТ ТӨХХ энэ хугацаанд 833 нислэг үйлдэж 208,749 зорчигч, 826 тонн ачаа тээвэрлэжээ. Өнөөдөр МИАТ компани Хонг Конг хот руу долоо хоногт 5 удаа буюу даваа, мягмар, пүрэв, баасан, ням гарагуудад нислэг үйлдэж байна.

Дашрамд дурдахад зорчигчдын тээшний журмыг шинэчлэн ширхэгийн системд шилжээд байна. Ингэснээр зорчигчдод энгийн ангилалаар аялсан тохиолдолд 23кг НЭГ ширхэг, бизнес ангилалаар аялсан тохиолдолд 32кг НЭГ ширхэг тээш үнэгүй тээвэрлэх боломжтой боллоо.

**ОНЦЛОХ МЭДЭЭ****Байт харвааны ДАШТ-ИЙ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО****Н.БАТЗАЯА**

Байт харвааны дэлхийн аварга шалгаруулах тэмцээн энэ сарын 1-4-нд болж, тэмцээний шагнал гардуулах үйл ажиллагаа онгорсон ням гарагч Чингисийн талбайд болж ондорлолоо. Шагнал гардуулах үйл ажиллагаанд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл, Ерөнхийлögчийн Тамгын газрын дарга, МБХХ-ны Ерөнхийлögч П.Цагаан болон албаны бусад хүмүүс оролцлоо. Энэ үеэр МБХХ-ны Ерөнхийлögч П.Цагаан “Би Монголын Байт харваан холбооны ерөнхийлögчөөр ажиллаад хоёр жил боллоо. Энэ хугацаанд олон ажил төловлож, зарим нь ажил хэрэг болон хэрэгжсэн. Энэ жил Монгол Улсад анх удаа Дэлхийн оюутны аварга шалгаруулах байт харвааны тэмцээн болж байна. Дээр үед зөвхөн монголчууд цэц мэргэнээ гайхуулж байсан бол өнөөдөр Эзэн Чингисийн талбайд олон орны тамирчид цэц мэргэнээ гайхуулан, орсойдлоо. Тэмцээн их амжилттай боллоо. Манай орны тамирчид

ч гэсэн туршилага хуримтлуулсан гэдэгт итгэлтэй байна. Бид цаашид байт харвааг илүү сурталчлах, бэлтгэлийн байртай болгох, сургуулийн бисийн тамирын боловсролын хотөлбөрт оруулах зэрэг олон ажил хийх хэрэгтэй байна. Мөн манай тамирчид Турк улсад болох дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож, багаараа олимпод орох эрхийн төлөө орсолдоно. Ер нь байт харвааны спортоор бид амжилт гаргахаар үндэслэлтэй. Учир нь харваа монголчуудын генд байдал. Гэхдээ энд материалыг баазаас эхлээд олон бэрхшээл бий. Тэр бүхэн сайжрахын хэрээр тамирчдын ур чадвар ч гэсэн сайжрах байх” гэв. Дэлхийн 11 удаагийн байт харвааны аварга шалгаруулах тэмцээний ганцаарчилсан эрэгтэй төрлийн I байрыг ОХУ-ын тамирчин Базарзапов Галсан, II байрт Хятадын Тайвань улсын тамирчин Лоу Вэй Мин, III байрт ОХУ-ын тамирчин Бобоф Серженков нар шалгарлаа. Дашрамд дурдахад, манай улсын байт харваа удахгүй бэлтгэлийн шинэ байртай болох гээн. Шинэ байрны шав тавих ёслол энэ сард болох юм байна.

# МОНГОЛЬН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Манай сонины III улирлын захиалга  
үргэлжилж байна

Улиралд **44 дугаар**

захиалгын үнэ **15400**

Монгол шуудан: 70078977  
УВ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

**ХААН банк**

	Авах	Зарах	Авах	Зарах	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	1980.00	1993.00	ФУНТ	2834.00	2915.00	АМ.ДОЛЛАР	1982.00	1993.00
ЕВРО	2211.00	2302.00	РУБЛЬ	28.60	32.40	ЕВРО	2169.00	2258.00
ИЕН	18.08	18.86	ЮАНЬ	299.00	304.00	ИЕН	17.84	18.65

Өчигдрийн 19.00 цагийн байдаа







# ОНЦЛОХ ХУУДАС

## Сенсаацийн эргэн тойронд

# ШАТАХ ЁСТОЙ БОЛ ШАТЬЯ ГЭЖ УРИАЛАХ НЬ ЗӨВ YY

Сүүлийн уед  
оөрийгээ шатаах нь бараг мода болоод  
байгаа гэхэд хилсдэхгүй. “Эрдэнэс Тавантолгой” компанийн  
ажилтан С.Эрдэнэ гэгч этгээд цэнхэр дэлгэцээр гарч байхдаа оөрийгээ  
шатаасанаас хойшийн хэрэг ойр, ойрхон олон гарсан байна. Тухайлбал, нэгэн эмэгтэй  
нохортэйгээ маргалдсанаас болж оорийгээ шатаасан, Хан-Уул дүүргийн нэгэн иргэн саванд  
бензин авч ирээд, гэртээ болон өөр дээрээ астаж, оөрийгээ гэртэйгээ галдан шатаахыг завдсан, улс  
торийн 21 нам Тусгаар тогтолын талбайд санал тоолох хар хайрцгийн шатаасан гээд ар араасаа олон үйлдэл  
цуварсаар байна. Тиймээс бид энэ удаагийнхаа “Онцлох хуудас” булангаар дээрх хэргүүдээс онцлон хүргж байна.

### НОХОРТЭЙГӨӨ МАРГАЛДАЖ, ӨӨРИЙГӨӨ ШАТААВ

/2016.06.03/

Өнгөрсөн долоо хоногийн баасан гарарт нэгэн эмэгтэй  
нохортэйгээ маргалдсанаас болж оөрийгээ шатаасан  
хэрэг гарсан. Тодруулбал, Баянзүрх дүүргийн есдүгээр  
хороонд оршин суух 32 настай С согтууруулах ундаа  
хэрэглэсэн үедээ нохортэйгээ маргалдан оөрийн  
цээж рүүгээ архи астган шатаасан байгаа юм. Одоо  
тухайн эмэгтэй ГССҮТ-ийн “Түлэнхийн тасаг”-т  
хүргэгдэн эмчилгэдэж байна. Хэргийг Баянзүрх  
дүүргийн Цагдаагийн гуравдугаар хэлтэст  
шалгаж байна.

ХҮҮХДҮҮД  
НЬ ААВЫГАА  
ХӨНӨӨГӨӨД,  
ШАТААЖЭЭ

/2016.05.24/

Төв аймгийн Алтанбулаг сумын  
нутаг Шувуун Фабрик орчмоос  
өнгөрсөн дөрөвдүгээр сарын 28-ны өдөр  
ул таних хүний шатсан цогцос олдсон. Тус  
хэргийг Төв аймгийн Цагдаагийн хэлтэс болон  
УМБГ-ын Онц хүнд гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс  
хамтран шалгасны дүнд талийгаачийг Чингэлтэй  
дүүргийн иргэн 53 настай Б болохыг тогтоожээ.  
Талийгаачийг амь насаа алдаа хоёр сар гаруйн  
хугацаа өнгөрөөд байхад ар гэрийнхэн нь цагдаагийн  
байгууллагад мэдэгдэж, эрэл сурал болохгүй  
байсан тул ойр дотны хүмүүс нь хөнөөсөн  
байж магадгүйгээ таамаг дэвшүүлсэн байна.  
Ингээд шалгалтын явцад талийгаачийг  
туүний хоёр хүүхэд 1987 онд төрсон  
Н, 1989 онд төрсон Б нар бүлэглэн  
хөнөөсөн болохыг тогтоожээ.

ЭССЕРГҮҮЦЭЛ УЗҮҮЛСЭН  
ЗАЛУУ АВТОБУСАА ШАТААНАА  
ГЭВ

/2016.05.19/

Баянгол дүүргийн нутаг,  
III-IV хороололд нэгэн залуу  
оөрийн эзэмшилжин том оврын  
автобустайгаа эсэргүүцэл илэрхийлж,  
төр засагс жирин иргэдэд худалдаа  
эрхлэх боломж олгохгүй бол автобусаа  
шатаанаа гэж уриа лоозон барьчихаад автобусан  
дээрээ олон цаг зогссон. Тэрбээр, автобусаа замын  
зорчих хэсэгт бус зориулалтын зогсоолд зогсоогоод  
кофе, ширлог зэрэг хонгон зуушны худалдаа эрхлэх  
гэтэл зөвшөөрөл авахаа гэгэл огөхгүй хэмээн  
холбогдох газраас нь хориглосон юм байна.  
Тиймээс ийнхүү эсэргүүцэлээ илэрхийлж  
байгаа аж. Харин түүний цагдаа нар  
болнулахаар оролцож байгаа бөгөөд  
нийгэмд хор хохирол учруулахуйц  
ноцтой байдал үүсгэхээс  
сэргийлж чаджээ.



“ШИЛЭН” ЦОГОО ХҮҮХЭЛДЭЙ ШАТААХ ГЭЭД...

/2016.02.22/

МАН-ын гишүүн Б.Цогтгэрэл буюу “Шилэн” Цогоо Үндэсний  
аудитын газрын үзүүндээ гэж төслийн үзүүлэлтэй “ҮАГ-т гомдол  
гаргаад 130 хоногийн иргэн наадам ямар ч хариу огөөгүй учраас миний  
бие болон иргэдийн төлөөлөл ҮАГ-т сууж хийж, тус газрын гадаа сор  
залахаар ирээд байна. Монгол төрийн байгууллагад шигдэж, хүнд суртал  
гаргаж байгаа нохдуудийг үтээр түргэн зайлцуулахын тулд энэ хүмүүсийн  
дүрээр сор залж байна” хэмээн тайлбарласан юм. Тэд “Зангад” гэсэн нэр  
наасан хүүхэлдэй дээр бензин астаж, шатаасан бөгөөд Б.Цогтгэрэлтэй явсан  
хоёр ч хүн гал унтраах үеэр шатахаа шахсан.

## Сэтгүүлчийн онцг

### ШАТДАГ, ШАТААДАГ “CHALLENGE”-ЫГ ТАСЛАН ЗОГСООГООЧ

#### Ж.ОТГОН

“Засгийн газраас манай  
компанийг дэмжихгүй,  
ямагт дарж байна” гэх  
үндэслэлээр С.Эрдэнэгэх нөхөр  
оөрийгээ шатаасан нь нийгмд  
тийм ч сайн үлгэр дуурайтай  
үзүүлэгээгүй. Энэхүү хэрэг явдал  
болсны дараалдоо хоногоос нь  
оөрийгээ шатаах “мода” газар  
авсан гэхэд хилсдэхгүй. Бүр  
залуусын дунд “Шатах ёстой  
бол шатья” гэдэг уг ч дэлгэрч,  
одоог хүртэл хэлэгдсээр байгаа.  
Айл бүрийн хойморт залардаг  
цэнхэр дэлгэцээр шууд гарч

байхдаа оөрийгээ шатаасан  
эрхэм компанийн болон улсын  
мөнгөөр БНСУ-д эмчилгээд  
ирсон. Монголдоо ирээд  
сенсаацийн дэгдээгээд байгаа  
хүн бүх ордог “уламжлалтай”  
болсон гэхэд хилсдэхгүй  
боловд байгаа “Цензуургийн  
яриа” нэвтрүүлэгт оролцсон  
гээд түүний дуулиан шуугиан  
одоо болтол намжаагүй байгаа.  
Монгол хүн амныхаа бэлгээр  
гэгчээр ийнхүү оөрийгээ  
шатаасан хэрэг явдлаас хойш  
шатаах уйл явдал тасралтгүй  
гарсаар байна. Энэхүү балмад  
уйл явдал газар авч архи,

согтууруулах ундаа хэрэглэсэн  
үедээ хэн нэгэнтэй маргалдаад  
оөрийгээ шатаах үйлдэл  
онгөрсөн оноос хойш хэд, хэдэн  
удаа гарлаа. Сүүлдээ бүр улс  
торийн нам, эзслийнхэн хүртэл  
төв талбай дээр санал хураах  
машин шатааж, намын гишүүд  
нь Засгийн газрын байрны  
гадна элдэв хүүхэлдэй шатааж  
“тэнзгэсэн”. Томчууд нь ингэж  
галдан шатаах давалгааг  
хөөрөгджэй, ухамсаргүйгээр  
даган дуурайж байгаа юм  
чинь тун удахгүй төлөвшиж  
амжаагүй буюу бяцхан үрс  
шатааж эхлэв. Бүр гэр бүлэйн

хүчирхийлэлд өртсөндөө тэсч  
чадалгүй аваачынхаа амийг  
хөнөөж, шатаасан хэрэг гарсан.  
Энэ мэтчилийн цаашлаад  
эцэг, эхдээ гомдоод, найз,  
нохцэлдэгийн муудалцаад  
оөрийгээ шатаавал гайхах зүйл  
алга. Хэрэвэ багцдаа загнуулаад  
дэвтэр, номоо сургуулийнхаа  
гадаа гаргаад, шатаагаад байвал  
томчуд бид хэнд гомдох билээ.  
Тэртэй тэргүй нүдэн дээр нь  
бараг өдөр бүр “гажиг” үйлдэл  
гаргаж, оөрийгээ болон элдэв  
зүйл шатаагаад байгаа юм чинь.  
Дээрх шиг шатаад, шатаагаад  
байгаа нохдуудийг төр засаг нь

мөнгө өгч гадаадад эмчлүүлэх  
бус харин чхатуухан хариуцлага  
тооцож, энхүү “challenge”-ыг  
таслан зогсох шаардлагатай  
байна. Тэгэхгүй бол архи,  
согтууруулах ундаа хэтрүүлэн  
хэрэглээн нохдууд гэр орноо,  
торсон биеэ, торол саднаа  
шатааж, төр засаг түшилцэж  
яваа нохөд нь төв талбайд  
түмэн олныг цуглувулж байгаа  
элдэв зүйл шатаадаг явдал  
тасрахгүй нь бололтай. Нэг л  
их эрх чөлөө ярж, эрхээ зэвж  
байгаа гэх нохдууд хэнд юу  
заагаад байгаагаа бодох цаг  
болжээ.





## ЗАВСАРЛАГА

# KING TOWER

PENTHOUSE & APARTMENT

## FORBES AWARDS-ЫН “ШИЛДЭГ ОРОН СУУЦ”-НЫ БОДИТ ХӨНГӨЛӨЛТ



Хотын төв цэгээс Зкм зайд, хамгийн цэнгэг агаартай бүсэд, Хатан туул гол, Богд хан уулын энгэрт, хамгийн том Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн баруун талд байрлах “Deluxe Marshall Village” хотоны “Luxury King Tower Apartment”-ыг Дэлхийн шилдгүүдийг шалгаруудаг FORBES AWARDS-ЫН “ШИЛДЭГ ОРОН СУУЦ”-аар тодорлоо. “Luxury King Tower Apartment” нь Франц архитекторын зураг төсөл, Герман инженерийн хяналтаар баригдаж буй бүрэн цутгамал, Таван одтой зочид буудлын стандарт бүхий тансаг зэрэглэлийн орон сууц юм.



DUPLEX ЗАГВАРЫН ОРОН СУУЦ



PENTHOUSE ЗАГВАРЫН ОРОН СУУЦ



DIAMOND АНГИЛАЛЫН ОРОН СУУЦ



CRYSTAL АНГИЛАЛЫН ОРОН СУУЦ

**19-119 сая төгрөгийн бодит хөнгөлөлт эдлэх боломж:** Та амьдралын үнэ цэнэтэй хором мөч бүрийг тайван, тав тухтай өнгөрүүлэх үл хөдлөх хөрөнгөө “Luxury King Tower Apartment”-ын Crystal, Diamond, Duplex болон Penthouse загвараас сонгож, 19-119 сая төгрөгийн хөнгөлөлтийг урьдчилгаа төлбөрөөс хамааран бодитоор эдлэх боломжийг танд олгож байна.



ХААН БАНК



ГОЛОМТ БАНК



ТӨРИЙН БАНК

**Засгийн газраас хэрэгжүүлж буй 8% зээлийг 7 хоногт шуурхай шийдвэрлэх:** Та Crystal ангилалын **80мкв** хүртэлх талбайтай 2-3 өрөө орон сууцнаас сонгосноор бидэнтэй хамтран ажилладаг Хаан банк, Худалдаа Хөгжлийн банк, Төрийн банк, Голомт банкны VIP салбаруудаар үйлчлүүлэн, ипотекийн **8% зээлээ 7 хоногийн дотор шуурхай** шийдүүлэх боломжтой.

**Та Luxury King Tower Apartment-ыг сонгосноор манай хотхон дотор байрлах өндөр зэрэглэлийн үйлчилгээний төвүүдээр замын түгжрэлд орж цаг алдалгүйгээр үйлчлүүлэх боломжтой**



- Монголын №1 Туяарах салон
- Холливудын оддыг хэрэглээг Монголд авч ирсэн “Intercharm” beauty residence
- Байгалийн цэвэр халгайн бүтээгдэхүүний үйлчилгэээрээз алдартай Eco beauty salon
- Spinning брэндийн дугуйт даасгал бүхий Evo studio



- Монтессори сургалттай “Миний гэр” цэцэрлэг
- Японы эзэн ханы нэрэмжит балетын сургууль
- Маршалын багачууд цэцэрлэг
- Эрдэнэбаяр & Мөнхцэцэг зураачдын урлан
- Marshall Art Gallery
- Тансаг зэрэглэлийн VIP snooker club



- Өргөн сонголт бүхий Наран супермаркет сүлжээ дэлгүүр
- Тансаг зэрэглэлийн VIP snooker club
- Гэрээсээ гаралгүйгээр үйлчлүүлэх боломжтой 24 цагийн авто угаалга
- Чанарыг илтгэх Герман хүнсний худалдааны төв



- “U3 MEDISPA” health and beauty clinic
- “Эрүүл энх баяс” уламжлалт эмнэлэг
- Швед мэргэжилтэнтэй “Marshal dental” шүүдний эмнэлэг
- Алхакал тайлагч “MUS” хөвөч төв
- Хүүхдийн эмнэлэг

[facebook.com/DeluxeMarshallVillage](https://facebook.com/DeluxeMarshallVillage)

[www.kingtower.mn](http://www.kingtower.mn), [www.marshallvillage.mn](http://www.marshallvillage.mn)

Холбоо барих утас: 88114186, 99997063, 88113067

Хаяг: Их тэнгэрийн амруу явах замд, Маршалын гүүрний хойд талд